

**БУЛГАН АЙМГИЙН ТӨСВИЙН  
ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧИЙН  
2020 ОНЫ ТӨСВИЙН  
ТӨСӨЛ**

**2019 ОН**

**АГУУЛГА****НЭГ. МОНГОЛ УЛСЫН МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН 2020 ОНЫ ХАНДЛАГА, 2021-2022 ОНЫ ТӨСӨӨЛӨЛ**

- 1.1 Гадаад худалдаа
- 1.2 Төлбөрийн тэнцэл
- 1.3 Инфляци

**ХОЁР. МОНГОЛ УЛСЫН 2020 ОНД БАРИМТЛАХ ТӨСВИЙН БОДЛОГО**

- 2.1 Төсвийн орлогын чиглэлээр
- 2.2 Төсвийн зарлагын чиглэлээр

**ГУРАВ: БУЛГАН АЙМГИЙН ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧИЙН ТӨСВИЙН ОРЛОГО**

- 3.1 Аймгийн 2019 оны төсвийн 10 дугаар сарын орлогын гүйцэтгэл, хүлээгдэж буй гүйцэтгэл
- 3.2 Аймгийн 2020 оны төсвийн нийт орлого ба тусламжийн дүн
- 3.3 Татварын орлого
- 3.4 Татварын бус орлого
- 3.5 Төсвийн орлогод учирч буй эрсдэл
- 3.6 Татварын хөнгөлөлт, чөлөөлөлт

**ДӨРӨВ. БУЛГАН АЙМГИЙН ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧИЙН ТӨСВИЙН УРСГАЛ ЗАРДАЛ**

- 4.1 Аймгийн 2019 оны төсвийн 10 дугаар сарын зарлагын гүйцэтгэл
- 4.2 Аймгийн 2020 оны төсвийн урсгал зардлын тойм
- 4.3 Орон нутгийн 2020 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөө
  - 4.3.1 Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт
  - 4.3.2 Орон нутгийн хөгжлийн сан
  - 4.3.3 Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлаас санхүүжих хөрөнгө оруулалт, хөтөлбөр төсөл арга хэмжээ
  - 4.3.4 Аймгийн авто замын сангийн хөрөнгө оруулалт
- 4.4 Орон нутгийн 2020 оны төсвийн үндсэн үзүүлэлтүүд

**ТАВ. ТУСГАЙ ЗОРИУЛАЛТЫН ШИЛЖҮҮЛГИЙН БАЙГУУЛЛАГЫН УРСГАЛ ТӨСВИЙН ТАНИЛЦУУЛГА**

- 8.1 Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд
  - 8.1.1 Ерөнхий боловсролын сургуулийн үйлчилгээ
  - 8.1.2 Сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээ
- 8.2 Эрүүл мэндийн сайд
  - 8.2.1 Эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээ
- 8.3 Хөдөлмөр, нийгмийн хамааллын сайд
  - 8.3.1 Гэр бүл, хүүхэд, залуучуудын үйлчилгээ
- 8.4 Барилга, хот байгуулалтын сайд
  - 8.4.1 Газрын харилцаа, геодези зураг зүй, барилга хот байгуулалтын үйлчилгээ

**ЗУРГАА. ТӨСВИЙН НЭМЭЛТ ТООЦООЛЛУУД**

## НЭГ. МОНГОЛ УЛСЫН МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН 2020 ОНЫ ХАНДЛАГА, 2021-2022 ОНЫ ТӨСӨӨЛӨЛ

Монгол Улсын эдийн засгийн өсөлтийг 2020-2022 онд урт хугацааны өсөлтийн түвшинд буюу 6 хувьд байлгахаар зорьж байна. Дунд хугацаанд худалдааны маргааны улмаас гадаад орчинд тодорхой бус байдал нэмэгдэж байгаа ч эдийн засгийн өсөлтийн зорилтод түвшинг хангахын тулд Засгийн газар дараах бодлогуудыг авч хэрэгжүүлнэ. Үүнд:

1. Төсөв, санхүүгийн сахилга батыг дээшлүүлэх, үр ашиггүй зардлыг бууруулах бодлогыг тууштай хэрэгжүүлж, макро эдийн засгийн орчны тогтвортой байдлыг хангана. Ингэснээр Монгол Улсын зээлжих зэрэглэлийг сайжруулж, хөрөнгө оруулагчдын итгэлийг нэмэгдүүлэх замаар Монгол Улсад орж ирэх хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлнэ.
2. Татвар, гаалийн шинэчлэлийг хэрэгжүүлэн бизнесийн орчныг сайжруулж, гадаад худалдааны эргэлтийг нэмэгдүүлнэ.
3. Банкны салбарт шинэчлэл хийж, тус салбарыг либералчлах эрхзүйн орчинг бүрдүүлж шударга өрсөлдөөнийг нэмэгдүүлнэ. Банк, санхүүгийн зах зээлд финтекийн дэвшлүүдийг нэвтрүүлж, санхүүгийн үйлчилгээний хүртээмж, үр нөлөөг сайжруулах замаар зээлийн хүүг бууруулж эдийн засгийн идэвхжилтийг дэмжинэ.
4. Эдийн засгийн өрсөлдөх чадварыг сайжруулах, үндэсний бүтээмжийг дээшлүүлэх төмөр зам, авто зам, цахилгаан эрчим хүч, цэвэрлэх байгууламж, газрын тос боловсруулах үйлдвэр зэрэг томоохон дэд бүтэц, үйлдвэрийн бүтээн байгуулалтыг хэрэгжүүлэх замаар эдийн засгийн урт хугацааны тогтвортой өсөлтийг хангана.
5. Аялал жуулчлалын бүс нутгуудыг хөгжүүлж, үндэсний өв соёл, урлагийн үзвэрүүдийн барилга, байгууламжийг сайжруулж, иргэнийг агаарын тээврийг либеральчлах замаар нислэгийн тийзний үнийг бууруулж, аялал жуулчлалын салбараас орох орлогыг нэмэгдүүлж, эдийн засгийн бүтцийг сайжруулах бодлогыг хэрэгжүүлнэ.

### 1.1 . Гадаад худалдаа

Монгол Улсын гадаад худалдааны нийт бараа эргэлт 2020 онд 14.5 тэрбум ам.долларт, 2021 онд 15.0 тэрбум ам.долларт тус тус хүрч, гадаад худалдааны тэнцэл 2020-2022 онд дундажаар 1.6 тэрбум ам.долларын ашигтай гарахаар төсөөлж байна.

Экспорт 2020 онд 7.8 тэрбум ам.долларт хүрэхээр төсөөлж байна. Дэлхийн зах зээл дэх алтны үнэ өндөр байх тул 2020 онд алтны экспортыг нэмэгдэхээр төсөөлж байна. Импорт 2020 онд 6.7 тэрбум ам.долларт хүрэхээр байна.

### 1.2. Төлбөрийн тэнцэл

Дунд хугацаанд уул уурхайн болон дэд бүтцийн томоохон төсөл, хөтөлбөрүүдийн хэрэгжилттэй холбоотойгоор импортын хэмжээ өсөх хүлээлттэй байна. Хөрөнгө, санхүүгийн дансны өөрчлөлтөд нөлөөлөх гол хүчин зүйлс нь гадаадын шууд хөрөнгө оруулалт, гадаад үнэт зүйлс, Олон Улсын Валютын сангийн “Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөр”-ийн хүрээнд орж ирэх төсвийн дэмжлэг зэрэг байна.

Оюутолгой төслийн далд уурхайн бүтээн байгуулалттай холбоотой хөрөнгө оруулалт тасралтгүй өсөх төлөвтэй байна. Олон Улсын Валютын Сангийн “Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөр”-ийн хүрээнд Дэлхийн банк, Азийн хөгжлийн банк, ЖАЙКА зэрэг байгууллагуудаас төсвийн дэмжлэгт зориулсан санхүүжилт орж ирэхээр байна.

### 1.3. Инфляци

Инфляцын түвшин дунд хугацаанд буюу 2020-2022 онд 8 орчим хувьд байхаар байна. Засгийн газраас татварын багц хуулийн шинэчлэл хийж, бизнесийн орчныг сайжруулах, 1.5 тэрбумаас бага орлоготой аж ахуйн нэгжүүдийн орлогын

албан татварыг 90 хувиар хөнгөлөх бодлого хэрэгжүүлнэ. Энэ нь бизнесийн зардлыг бууруулж, үйлдвэрлэл, нийт нийлүүлэлтийг нэмэгдүүлэх тул инфляцын түвшнийг зорилтод хэмжээнд, тогтвортой байлгах боломж бүрдэнэ.

**Макро эдийн засгийн төсөөлөлд учирч болзошгүй дараах эрсдэл:**

1. АНУ болон БНХАУ-ын хоорондын худалдааны маргаан цаашид хэрхэн үргэлжлэх, БНХАУ-ын эдийн засгийн өсөлтийн сааралт түүхий эдийн эрэлтэд хэрхэн нөлөөлөх, мөн БНХАУ болон бусад томоохон орнуудын хэрэгжүүлж буй бодлого өөрчлөгдөх зэрэг гадаад орчны тодорхой бус хүчин зүйлүүд нь экспортын түүхий эдийн үнэ, эрэлтэд нөлөөлөх эрсдэл байна.
2. Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх Ази, номхон далайн бүсийн байгууллага/АНДББ/-ын МонголУлсад өгсөн зөвлөмжийн үнэлгээнүүдийг сайжруулж, тодорхой ахиц гаргаж байгаа хэдий ч 2019 оны 10 дугаар сард болох ФАТФ-ын хуралдаанаар Монгол Улс тус байгууллагын хяналт/саарал жагсаалт/-д орох өндөр эрсдэлтэй хэвээр байна. Саарал жагсаалтад орсон тохиолдолд гадаад гүйлгээ хүндрэлтэй болох, хөрөнгө оруулагчдын итгэл сулрах, зээлжих зэрэглэл буурах, гадаад төлбөр тооцооны зардал нэмэгдэж, хугацаа удаашрах эрсдэл үүсэж болзошгүй байна.
3. Арилжааны банкуудад хийсэн активын чанарын үнэлгээний мөрөөр банкнуудын өөрийн хөрөнгийг нэмэгдүүлэх ажлын хэрэгжилт хангалтгүй байна. Монголбанкнаас банкуудын өөрийн хөрөнгийг нэмэгдүүлсэн эх үүсвэрийн гарал үүсэл, өөрийн хөрөнгөнд тооцогдох боломжтой эсэхийг магадлан шалгах шалгалтыг олон улсын мэргэжлийн байгууллагатай хамтран хэрэгжүүлсэн. Шалгалтын үр дүнд үндэслэн банкуудад өөрийн хөрөнгөө өсгөх шаардлагыг тавьж, хэрэгжүүлж чадахгүй нөхцөлд санхүүгийн салбарт хүндрэл үүсэх эрсдэлтэй байна.
4. Цаг уурын урьдчилсан судалгаагаар энэ өвөл хур тунадасны хэмжээ олон жилийн дунджаас өндөр байх магадлалтай байгаа тул өвөлжилт хүндэрч болзошгүй юм.
5. Махны нийлүүлэлтийн сүлжээг сайжруулахад чиглэсэн зохион байгуулалтын арга хэмжээ шуурхай хэрэгжүүлэхгүй бол экспортод гаргах махны хэмжээ нэмэгдэх, дотоодын зах зээлд худалдаалагдах махны үнэд огцом нөлөөлж болзошгүй байна.

## ХОЁР. МОНГОЛ УЛСЫН 2020 ОНД БАРИМТЛАХ ТӨСВИЙН БОДЛОГО

Засгийн газраас авч хэрэгжүүлж буй “Цахим, ил тод, үр ашигтай” төсвийн бодлогын үр дүнд эдийн засгийн өсөлт сэргэж 2019 оны эхний хагас жилийн байдлаар 7.3 хувьд хүрч, 2018 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлээр төсвийн тэнцэл 27.8 тэрбум төгрөгийн ашигтай гарсан нь 2010 оноос хойш Монгол Улсын нэгдсэн төсөв 8 жилийн дараа анх удаа гарсан эерэг үзүүлэлт боллоо.

2020 онд **Эдийн засгийн тогтвортой өсөлтийг дэмжих “Цахим, ил тод, үр ашигтай”** төсвийн бодлогыг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ. Үүнд:

<p><b>1</b> Төсвийн сахилга батыг тууштай үргэлжлүүлэн, төсвийг эрүүлжүүлэх, алдагдлыг үе шаттай бууруулах бодлогыг хэрэгжүүлнэ</p>	<p><b>5</b> Зарлагын реформыг үргэлжлүүлэн хэрэгжүүлж, үр ашиг, хүртээмжийг нэмэгдүүлнэ</p>
<p><b>2</b> Засгийн газрын 2012-2016 онд гаргасан бондуудыг 2021-2023 онуудад эргэн төлөхтэй холбогдуулан төсвийн алдагдлыг Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан хэмжээнээс сайжруулан 2021 онд ДНБ-ий -2.8 хувь, 2022 онд ДНБ-ий -1.4 хувь, цаашид 2023 оноос ашигтай гаргах бодлого баримтална</p>	<p><b>6</b> Гаалийн шинэчлэлийг хэрэгжүүлж дуусгаснаар гадаад худалдааны эргэлтийг нэмэгдүүлж, байгалийн баялгаас татварыг бүрэн хураах боломжийг бүрдүүлнэ</p>
<p><b>3</b> Засгийн газрын зүгээс 2021-2024 онуудад төлөгдөх нийт 2.9 тэрбум ам.долларын өндөр хүүтэй гадаад үнэт цаасны төлбөрийг эдийн засаг, төсөвт дарамт үүсгэхгүй байх өрийн менежментийг хэрэгжүүлнэ</p>	<p><b>7</b> Өмнөх жилүүдэд эхлүүлсэн хөрөнгө оруулалтын ажлуудыг бүрэн дуусгаж, нийгэмд тулгамдсан төсөл хөтөлбөрүүдийг эхлүүлнэ</p>
<p><b>4</b> Бизнес, хөрөнгө оруулалт, хөдөлмөр эрхлэлтийг дэмжсэн татварын шинэчлэлийг хэрэгжүүлнэ</p>	<p><b>8</b> “Сумын шинэчлэл”-ийн төвийн бүтээн байгуулалтыг эхлүүлэх ажлын хүрээнд бүс тус бүрээс нэг сумыг хамруулна</p>

### 2.1. Төсвийн орлогын чиглэлээр:

**а/ Гаалийн шинэчлэл:** Монгол Улсын Засгийн газраас хэрэгжүүлж буй “Гаалийн шинэчлэл”-ийн хүрээнд БНХАУ-ын буцалтгүй тусламж болон улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Замын-Үүд, Алтанбулаг, Гашуунсухайт боомтуудыг олон улсын жишигт нийцүүлэн шинэчлэх, хүчин чадлыг нэмэгдүүлж зорчигч тээвэр, ачаа тээврийн барилга байгууламж, иж бүрэн шугам сүлжээ, дэд бүтэц, зам талбай, ногоон байгууламжийн цогцолборууд барьж байгуулах бүтээн байгуулалтын ажлыг 2020 онд

хэрэгжүүлж дуусгана. Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр Бичигт, Боршоо боомтын шинэчлэлийн ажлыг 2020 онд эхлүүлнэ.

**б/ Татварын шинэчлэл:** Эдийн засаг, хөрөнгө оруулалт, бизнес эрхлэгчдийг дэмжих зорилгоор Монгол Улсын Их Хурлаас 2019 оны 3 дугаар сарын 22-ны өдөр баталсан Татварын ерөнхий хууль, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хууль, Хувь хүний орлогын албан татвар татварын тухай хуулийн шинэчилсэн найруулга болон дагалдах бусад хуулийн шинэчлэлийг 2020 оноос хэрэгжүүлэн ажиллана. Татварын шинэчлэлийн хүрээнд татвар төлөгч иргэн, аж ахуйн нэгжийн татварын ачаалал буурч, татварын хялбаршуулсан горим хэрэгжиж, татварын бүртгэл, тайлагнал цахим хэлбэрт бүрэн шилжинэ.

**в/ Газрын бүртгэлийг цахимжуулж, ил тод болгоно:** Монгол Улсын Засгийн газраас газрын бүртгэлийн мэдээллийг ил тод болгох, газрын төлбөр ногдуулалт, төлөлтийг цахимжуулах замаар газар эзэмшиж, ашиглаж байгаа иргэн, аж ахуйн нэгжүүд газрын төлбөрөө хялбараар төлөх боломжийг бүрдүүлж, газрын төлбөрийн орлогыг бүрэн хураадаг болно. Газар хамгаалах, нөхөн сэргээхтэй холбоотой үүсэж буй хүндрэлийг сум, дүүрэг нь бие даан шийдвэрлэх боломжийг олгох зорилгоор газрын төлбөрийн орлогын 40 хувийг тухайн сум, дүүргийн төсөвт хуваарилах эрх зүйн орчныг бүрдүүлнэ.

## 2.2. Төсвийн зарлагын чиглэлээр:

Нийгмийн суурь үйлчилгээний чанар, хүртээмж, иргэдийн бодит орлогыг нэмэгдүүлэх, төсвийн урсгал зарлагын реформыг үргэлжлүүлэн хэрэгжүүлж төсвийн үр ашиг, хүртээмжийг сайжруулах бодлогын хүрээнд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ. Үүнд:

Боловсролын эрэлт, нийлүүлэлтийг зохистой хангах, чанартай боловсролын тогтолцоог дэмжинэ.	Хөдөлмөрийн зах зээлийн эрэлт шаардлагад нийцсэн мэргэжилтэн бэлтгэх зорилгоор МСҮТ-д суралцагчид 2019 оноос олгож эхэлсэн 100.0 мянган төгрөгийн тэтгэлгийг 2 дахин нэмэгдүүлж 200.0 мянган төгрөгт хүргэнэ.  2012 оноос хойш нэмэгдүүлээгүй цэцэрлэгийн хүүхдийн хоол болон ЕБС-ийн Үдийн цай хөтөлбөр, дотуур байрны хоолны зардлыг 50 хувиар тус тус нэмэгдүүлнэ.
Эрүүл мэндийн салбарт чанартай	Төр, хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагын тусламж үйлчилгээний тарифыг ижил тогтоож, нэмэгдүүлнэ.
үйлчилгээг бий болгох нөхцөлийг	Иргэн амбулаторийн оношилгоо, хөнгөлөлттэй эм, хэвтүүлэн эмчлэх үйлчилгээг нэг дор цогц байдлаар авах боломж олгоно.
бүрдүүлж, санхүүжилтийн ялгавартай байдлыг арилгана.	Төрийн өмчийн эмнэлгүүд үзүүлсэн тусламж үйлчилгээний тоо хэмжээ, чанарт тохирсон санхүүжилт авч, төсвийн менежментээ бие даан хэрэгжүүлдэг болно.

---

Ахмад настан, эхчүүд, малчид, хувиараа хөдөлмөр эрхлэгчид, болон төрийн албан хаагчийн бодит орлогыг нэмэгдүүлнэ.	2014 оноос хойш нэмэгдүүлээгүй байсан цалин, тэтгэвэр, тэтгэмжийг инфляцтай уялдуулж 2018 оноос жил бүр нэмэгдүүлж байгаа Засгийн газрын бодлогыг үргэлжлүүлнэ.
	Төрийн үйлчилгээний албан хаагч нь төрийн захиргааны албан хаагчийн нэгэн адил төрд ажилласан хугацаагаараа тооцуулж цалингийн нэмэгдэл, тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн тэтгэмж авах боломжийг 2020 оноос эхлэн олгоно.
	Малчид, хувиараа хөдөлмөр эрхлэгчид 1995-2019 оны хооронд төлж чадаагүй шимтгэлээ 2020 онд нэг удаа нөхөн төлж, тэтгэвэр авах боломжтой болно.
	Эхчүүдийн нийгмийн хамгааллыг сайжруулна.
	Хөнгөлөлттэй нөхцөлөөр эрт тэтгэвэр тогтоолгосон зарим эхчүүд, эмэгтэйчүүдийн тэтгэврийн хэмжээг нэмэгдүүлнэ.

---

## ГУРАВ: БУЛГАН АЙМГИЙН ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧИЙН ТӨСВИЙН ОРЛОГО

### 3.1 Аймгийн 2019 оны төсвийн 10 дугаар сарын орлогын гүйцэтгэл, хүлээгдэж буй гүйцэтгэл

Аймгийн төсвийн нийт урсгал орлого, тусламж шилжүүлгийн дүн 2019 оны 10 сарын байдлаар төлөвлөсөн хэмжээнээс 2.4 хувь буюу 1115.9 сая төгрөгөөр тасарсан байна.

Хүснэгт №1.2019 оны 10 сарын төсвийн орлого, тусламж шилжүүлгийн гүйцэтгэл /мян.төг/

Орлогын нэр төрөл	2018 он	2019 он			
	Гүйцэтгэл	Жилийн төлөвлөгөө	Тайлант үеийн төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
<b>НИЙТ ОРЛОГО</b>	<b>55,913,465.10</b>	<b>57,996,414.70</b>	<b>47,725,424.20</b>	<b>46,609,531.80</b>	1,115,892.4
<b>ОРОН НУТГИЙН ТӨСӨВТ ТӨВЛӨРҮҮЛЭХ ОРЛОГО</b>	<b>23,186,239.50</b>	<b>22,924,629.1</b>	<b>18,643,577.8</b>	<b>18,116,082.6</b>	527,495.2
<b>ТАТВАРЫН ОРЛОГО</b>	<b>22,538,034.80</b>	<b>22,263,502.1</b>	<b>18,140,585.5</b>	<b>17,332,295.9</b>	808,289.6
<b>Хувь хүний орлогын албан татвар</b>	<b>5,163,256.60</b>	<b>5,560,732.3</b>	<b>4,410,267.8</b>	<b>4,320,124.7</b>	90,143.1
Цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого	3,946,422.00	4,257,300.00	3,428,000.0	3,397,932.6	30,067.4
Үйл ажиллагааны орлого	106,398.10	108,862.00	72,592.0	111,535.6	(38,943.6)
Хөрөнгийн орлого	476,461.80	490,679.00	400,771.0	473,169.2	(72,398.2)
Шууд бус орлого	633,974.70	703,891.30	508,904.8	337,487.3	171,417.5
Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	(533,159.00)	(600,000.00)	(600,000.0)	(535,383.8)	(64,616.2)
<b>Хөрөнгийн албан татвар</b>	<b>771,392.1</b>	<b>770,622.5</b>	<b>654,567.0</b>	<b>711,288.5</b>	(56,721.5)
Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар	425,352.40	424,400.00	355,400.0	370,052.8	(14,652.8)
Бууны албан татвар	60,183.10	66,222.50	44,267.0	34,315.5	9,951.5
Авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар	285,856.60	280,000.00	254,900.0	306,920.2	(52,020.2)
<b>Бусад татвар</b>	<b>17,136,545.1</b>	<b>16,532,147.3</b>	<b>13,675,750.7</b>	<b>12,836,266.5</b>	839,484.2
Улсын тэмдэгтийн хураамж	169,885.20	185,896.20	147,231.3	117,194.2	30,037.1
Газрын төлбөр	<b>247,240.5</b>	<b>245,000.0</b>	<b>200,500.0</b>	<b>461,328.7</b>	(260,828.7)
Үүнээс: Газрын төлбөр	196,098.60	238,000.00	200,500.0	360,328.7	(159,828.7)
Дуудлага худалдаа, сонгон шалгаруулалт	51,141.90	7,000.00	-	101,000.0	(101,000.0)
Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр	70,691.70	61,045.00	52,995.0	74,776.2	(21,781.2)
Хог хаягдлын үйлчилгээний хураамж	115,920.20	143,819.60	114,850.4	93,838.5	21,011.9
Байгалийн нөөц ашигласны төлбөр	16,526,283.7	15,883,954.0	13,149,374.0	12,082,275.2	1,067,098.8
Үүнээс: Байгалийн ургамал ашигласны төлбөр	1,414.60	1,200.00	820.0	260.8	559.2
Ус рашааны нөөц ашигласны төлбөр	16,186,347.60	15,549,886.00	12,940,256.0	11,881,290.5	1,058,965.5
Ойн нөөц ашигласны төлбөр	319,280.80	296,510.00	185,335.5	186,993.7	(1,658.2)



Ан амьтны нөөц ашигласны төлбөр	19,240.70	36,358.00	22,962.5	13,730.2	9,232.3
Ашигт малтмалаас бусад байгалийн баялаг ашиглахад олгох эрхийн зөвшөөрлийн хураамж	5,863.80	12,432.50	10,800.0	6,410.7	4,389.3
Бусад	660.00	-	-	443.0	(443.0)
<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>648,204.7</b>	<b>661,127.0</b>	<b>502,992.3</b>	<b>783,786.7</b>	<b>(280,794.4)</b>
Хувьцааны ногдол ашиг	-	25,000.00	-	6,427.9	(6,427.9)
Хүү, торгуулийн орлого	526,040.50	503,733.00	422,488.3	639,790.3	(217,302.0)
Түрээсийн орлого	28,031.10	26,900.00	21,550.0	16,198.0	5,352.0
Төсвийн байгууллагын өөрийн орлого/ сумдын ЗДТГ-ын орлого/	33,000.00	33,000.00			-
Нэр заагдаагүй бусад орлого	61,133.10	52,494.00	43,954.0	103,390.5	(59,436.5)
<b>ХӨРӨНГИЙН ОРЛОГО</b>	<b>-</b>	<b>20,000.00</b>	<b>15,000.0</b>	<b>17,980.0</b>	<b>(2,980.0)</b>
Хөрөнгө борлуулсаны орлого	-	20,000.00	15,000.0	17,980.0	(2,980.0)
Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	32,727,225.60	35,071,785.60	29,081,846.40	28,493,449.20	588,397.2

Бүтцийн хувьд 2019 оны батлагдсан төлөвлөгөөг авч үзвэл татварын орлогоор 22263.5 сая буюу 38.4 хувийг, татварын бус орлогоор 623,4 сая буюу 1.1 хувийг, тусламж шилжүүлгийн орлогоор 35071.8 сая төгрөг буюу 60.5 хувийг бүрдүүлсэн байна.

Төсвийн орлого тасарсан гол шалтгаан нь Эрдэнэт үйлдвэр техник, технологийн шинэчлэл хийж ашигласан ус буюу саарал ус дахин үйлдвэрлэлд ашиглаж байгаа учраас усны Эрдэнэт үйлдвэр Төрийн өмчит үйлдвэрийн газраас орох орлого тасарч төсвийн орлогод сөргөөр нөлөөж байна.

### 3.2. Аймгийн 2019 оны төсвийн орлогын хүлээгдэж байгаа гүйцэтгэл

2019 оны аймгийн төсвийн нийт орлого, тусламжийн дүн хүлээгдэж буй гүйцэтгэлээр 54,7 тэрбум төгрөгт хүрч, төлөвлөснөөс 1.3 тэрбум төгрөгөөр тасархаар байна.

Хүснэгт №2. Аймгийн төсвийн урсгал орлогын хүлээгдэж буй гүйцэтгэл /мян.төг/

ҮЗҮҮЛЭЛТ	2019 Төлөвлөгөө	10 Сар гүйцэтгэл	ХБГ	Зөрүү
<b>НИЙТ ОРЛОГО</b>	22,891,629.1	18,116,082.6	21,618,943.5	1,272,685.6
<b>ОРОН НУТГИЙН ТӨСӨВТ ТӨВЛӨРҮҮЛЭХ ОРЛОГО</b>	<b>22,891,629.1</b>	<b>18,116,082.6</b>	<b>21,618,943.5</b>	1,272,685.6
<b>ТАТВАРЫН ОРЛОГО</b>	<b>22,263,502.1</b>	<b>17,332,295.9</b>	<b>20,775,805.4</b>	1,487,696.7
<b>Орлогын албан татвар</b>	<b>22,263,502.1</b>	<b>17,332,295.9</b>	<b>20,775,805.4</b>	1,487,696.7
<b>Хувь хүний орлогын албан татвар</b>	<b>5,560,732.3</b>	<b>4,320,124.7</b>	<b>5,177,766.3</b>	382,966.0
Цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого	4,257,300.00	3,397,932.6	4,100,000.0	157,300.0
Үйл ажиллагааны орлого	108,862.00	111,535.6	112,000.0	(3,138.0)
Хөрөнгийн орлого	490,679.00	473,169.2	490,679.0	-
Шууд бус орлого	703,891.30	337,487.3	475,087.3	228,804.0
Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	(600,000.00)	(535,383.8)	(535,383.8)	(64,616.2)
<b>Хөрөнгийн албан татвар</b>	<b>770,622.50</b>	<b>711,288.5</b>	<b>799,622.5</b>	(29,000.0)
Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар	424,400.00	370,052.8	424,400.0	-
Бууны албан татвар	66,222.50	34,315.5	66,222.5	-
Авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар	280,000.00	306,920.2	309,000.0	(29,000.0)

<b>Бусад татвар</b>	16,532,147.30	<b>12,836,266.5</b>	<b>15,333,800.4</b>	1,198,346.9
Улсын тэмдэгтийн хураамж	185,896.20	117,194.2	136,098.3	49,797.9
Газрын төлбөр	245,000.00	461,328.7	540,000.0	(295,000.0)
Үүнээс: Газрын төлбөр	238,000.00	360,328.7	439,000.0	(201,000.0)
Дуудлага худалдаа, сонгон шалгаруулалт	7,000.00	101,000.0	101,000.0	(94,000.0)
Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр	61,045.00	74,776.2	76,845.9	(15,800.9)
Хог хаягдлын үйлчилгээний хураамж	143,819.60	93,838.5	133,767.6	10,052.0
Байгалийн нөөц ашигласны төлбөр	15,883,954.00	12,082,275.2	14,440,234.9	1,443,719.1
Үүнээс: Байгалийн ургамал ашигласны төлбөр	1,200.00	260.8	500.0	700.0
Ус рашааны нөөц ашигласны төлбөр	15,549,886.00	11,881,290.5	14,127,290.5	1,422,595.5
Ойн нөөц ашигласны төлбөр	296,510.00	186,993.7	296,510.0	-
Ан амьтны нөөц ашигласны төлбөр	36,358.00	13,730.2	15,934.4	20,423.6
Ашигт малтмалаас бусад байгалийн баялаг ашиглахад олгох эрхийн зөвшөөрлийн хураамж	12,432.50	6,410.7	6,410.7	6,021.8
Бусад	-	443.0	443.0	(443.0)
<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>628,127.0</b>	<b>783,786.7</b>	<b>843,138.1</b>	(215,011.1)
Хувьцааны ногдол ашиг	25,000.00	6,427.9	40,747.6	(15,747.6)
Хүү, торгуулийн орлого	503,733.00	639,790.3	660,000.0	(156,267.0)
Түрээсийн орлого	26,900.00	16,198.0	17,000.0	9,900.0
Нэр заагдаагүй бусад орлого	52,494.00	103,390.5	105,390.5	(52,896.5)
<b>ХӨРӨНГИЙН ОРЛОГО</b>	<b>20,000.00</b>	<b>17,980.0</b>	<b>20,000.0</b>	-
Хөрөнгө борлуулсаны орлого	20,000.00	17,980.0	20,000.0	-

2019 оны жилийн эцсээр татварын орлого 20775.8 сая төгрөгт хүрч, төлөвлөсөн хэмжээнээс 1487.7 сая төгрөг буюу 9.0 хувиар тасрах бол татварын бус орлого 874.1 сая болж, төлөвлөснөөс 213 сая төгрөг буюу 32.2 хувиар өсөхөөр байна. Нийт дүнгээрээ төсвийн орлого өмнөх оны гүйцэтгэлээс 2.5 хувь буюу 1.3 тэрбум төгрөгөөр тасрах тооцоо гарлаа.

### 3.3. Татварын орлого

Төсвийн орлогыг тооцоолохдоо 2020 оны 01 сарын 01-ний өдрөөс хэрэгжиж эхлэх Татварын шинэ хууль, эрх зүйн орчныг шинээр мөрдөнө. Үүнд:

- Хувь хүний орлогын албан татварын хөнгөлөлтийн хэмжээг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ, үнийн өсөлтийн түвшин зэрэгтэй уялдуулан цалин, хөдөлмөрийн хөлсний хэмжээнээс хамааран нэмэгдүүлэхээр шийдвэрлэсэн. 2020 оноос албан татвар ногдуулах жилийн орлогын хэмжээ 0-6,0 сая төгрөг хүртэл хувь хүний орлогын албан татварын хөнгөлөлт 240.0 мянга, 6.0-12.0 сая төгрөг хүртэл 216.0 мянга, 12.0-18.0 сая төгрөг хүртэл 192.0 мянга, 18.0-24.0 сая төгрөг хүртэл 168.0 мянга, 24.0-30.0 сая төгрөг хүртэл 144.0 мянга, 30.0-36.0 сая төгрөг хүртэл 120.0 мянган төгрөг, 36.0 сая төгрөгөөс дээш бол хөнгөлөлт тооцохгүй байхаар батлагдсан байна.
- Цалин, хөдөлмөрийн хөлс болон түүнтэй адилтгах орлогын албан татвараар 2018 онд 3.9 тэрбум төгрөг төвлөрсөн ба 80.0 хувийг төр төсвийн байгууллагуудад ажиллагсдын цалин хөлсний орлого болон түүнтэй адилтгах орлогын албан татвараас бүрдэж байгаа бөгөөд 2020 онд цалин, хөдөлмөрийн хөлс болон түүнтэй адилтгах орлогыг 4.1 тэрбум төгрөгөөр тооцлоо.

- Хуулийн этгээд байгуулахгүйгээр бие даан мэргэжлийн үйлчилгээ, үйлдвэрлэл, арилжаа эрхэлж олсон орлогод ногдох орлогыг нэмж тооцон үйл ажиллагааны орлогыг нийт 120.0 сая төгрөгөөр тооцлоо.
- ХААН банк, Төрийн банк, Хас банкинд хадгаламж эзэмшигч иргэдийн судалгаанд үндэслэн хадгаламжийн хүүний орлогод татвар ногдуулж хөрөнгийн орлогыг бүрдүүлэхээр 539.2 сая төгрөг төлөвлөж, сумдад хуваариллаа.
- Засгийн газрын 2019 оны 343-р тогтоолын дагуу хоршооны гишүүн малчин, мал бүхий иргэдэд олгох хонины ноосны килограмм тутамд олгох урамшууллыг 1500 төгрөгөөр, тэмээний ноосыг 2000 төгрөгөөр тооцон, ноосны урамшууллын орлогоос татвар авахаар тооцон 147.9 сая төгрөг, шууд бус орлогыг 312.1 сая төгрөгөөр тооцлоо.
- Хувь хүний орлогын албан татварын буцаан олголтоор 2019 онд 1141 иргэнд 535.4 сая төгрөгийг олгосон бөгөөд жилд дунджаар 20,0-50,0 сая төгрөгөөр нэмэгдэж байна. Иймээс 2020 онд 600.0 сая төгрөг олгохоор тооцлоо.

2015-2019 оны хувь хүний орлогын албан татварын  
буцаан олголтын судалгаа /сая.төг/

№	Үзүүлэлт	2016 гүйц	2017 гүйц	2018 гүйц	2019 гүйц	2020 төлөвлөгөө
1	Хүний тоо	1191	1158	1202	1141	1213
2	Олгосон дүн /сая.төг/	470,6	495,2	553,2	535,4	600.0

***Хөрөнгийн албан татвар***

Хөрөнгийн албан татварын орлогод үл хөдлөх хөрөнгийн албан татвар, бууны албан татвар, авто тээвэр болон өөрөө явагч хэрэгслийн албан татварын орлогыг хамааруулж, нийт 815.9 сая төгрөгөөр төлөвлөв. Бүтцийн хувьд авч үзвэл үл хөдлөх хөрөнгийн албан татварын орлого 460.0 сая буюу 56.4 хувь, бууны албан татварын орлого 60.9 сая буюу 7.5 хувь, авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татварын орлого 295.0 сая буюу 36.1 хувийг эзэлж байна.

Дээрх орлогыг өмнөх жилүүдийн гүйцэтгэл болон энэ оны хүлээгдэж байгаа гүйцэтгэлд үндэслэн тооцсон болно.

***Бусад татвар, төлбөр хураамж***

Төрийн эрх бүхий байгууллагаас Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд заасан үйлчилгээ үзүүлсний төлөө иргэн, хуулийн этгээдийн төлж байгаа тэмдэгтийн хураамжийн сүүлийн 5 жилийн гүйцэтгэлд үндэслэн 165.0 сая төгрөгөөр тусгалаа.

2019 оны хүлээгдэж буй гүйцэтгэлд үндэслэн түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөрийн хураамжийн орлого 63.0 сая, ашигт малтмалаас бусад байгалийн баялаг ашиглахад олгох эрхийн зөвшөөрлийн хураамжийн орлогыг 3.5 сая төгрөгөөр төлөвлөлөө.

2020 оны хог хаягдлын үйлчилгээний хураамжийн орлогыг сумын ИТХурлаар тогтоосон үнэлгээг харгалзан, сумын төвийн өрхийн 90,0%-иар тооцон 136.5 сая төгрөгөөр төлөвлөв.

Засгийн газрын 2018 оны 182-р тогтоол, АИТХ-ын тэргүүлэгчдийн хуралдаанаар батлагдсан “Газрын төлбөрийн бааз” болон “Газар зохион байгуулалтын төлөвлөгөө”-д тусгасны дагуу газрын төлбөрийн орлогыг Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газартай хамтран тооцож 421.0 сая төгрөг, дуудлага худалдааг 20 сая төгрөгөөр тус тус орлогын төлөвлөгөөнд тусгалаа.

2019 оны хүлээгдэж буй гүйцэтгэлээр ойгоос мод түлээ бэлтгэж ашигласны төлбөрийн хураамжийн орлого биелж байна. Иймд ойн нөөцийг харгалзан үзэж 320.0 сая төгрөгийн орлого төсөвт төвлөрүүлэхээр тооцлоо.

Ан амьтны нөөц ашигласны төлбөрийн орлогоор Бугат, Орхон, Сэлэнгэ, Тэшиг, Хутаг-өндөр суманд 22.2 сая төгрөгний орлого төлөвлөлөө.

Ус ашигласны төлбөрийн орлогыг 14.6 тэрбум төгрөгөөр төлөвлөж байна.

2019 онд хүлээгдэж байгаа гүйцэтгэлээр ус ашигласны төлбөрийн орлогоор 14225.0 сая төгрөг орохоор төлөвлөсний 12315.0 сая төгрөг буюу 86.5 хувийг Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-аас орох орлого эзэлж байна. Бусад уул уурхайн аж ахуйн нэгжүүдийн усны төлбөрийн орлого 1,7 тэрбум төгрөг буюу 13,5%-ийг эзэлж байна.

Эрдэнэ үйлдвэр ТӨҮГ нь саарал усаа ашиглаж байгаа нь 2019 онд төсөвт төвлөрөх орлогын төлөвлөгөө тасрах цаашид тухайн технологийг ашиглах, мөн алтны компаниудын өмнөх онуудын /2017-2018/ дутуу төлбөрийг гүйцэд төвлөрүүлсэн зэргийг харгалзан усны төлбөрийн орлогын төлөвлөгөөг өмнөх онтой харьцуулахад 6.8 хувиар бууруулж төлөвлөлөө.

### **3.4 Татварын бус орлого**

2020 оны аймаг, сумын төсөвт татварын бус орлогоор 575.0 сая төгрөг төлөвлөснөөс хүү, торгуулийн орлогоор 505.0 сая, түрээсийн орлогоор 25.0 сая, бусад орлогоор 25.0 сая, төрийн болон орон нутгийн өмчид бүртгэлтэй хөрөнгө борлуулсны орлогоор 20,0 сая төгрөг оруулахаар төлөвлөлөө. Дээрх орлогуудыг 2017, 2018 оны гүйцэтгэл, 2019 оны хүлээгдэж буй гүйцэтгэлд үндэслэн тооцсон болно.

## ДӨРӨВ. БУЛГАН АЙМГИЙН ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧИЙН ТӨСВИЙН УРСГАЛ ЗАРДАЛ

### 4.1 Аймгийн 2019 оны төсвийн 10 дугаар сарын зарлагын гүйцэтгэл

Аймгийн төсвийн нийт зардал 2019 оны 10 дугаар сарын байдлаар 64,8 тэрбум төгрөгөөр төлөвлөгдсөнөөс 54,1 тэрбум төгрөгийн буюу 85,0 хувийн гүйцэтгэлтэй байна.

Хүснэгт №3 Төсвийн зарлагын эхний 10 дугаар сарын гүйцэтгэл, төсвийн бүрэлдэхүүнээр /сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Нэгдсэн төсөв	Аймгийн төсөв	Сумын төсөв	ТЗШ-ийн төсөв
Жилийн төлөвлөгөө	64,837.5	21,526.3	13,119.9	30,191.3
Сарын төлөвлөгөө /10 сарын өссөн дүнгээр/	54,056.8	17,565.7	11,549.5	24,941.6
Гүйцэтгэл	45,781.8	14,650.7	8,877.2	22,253.9
Хувь	84.7%	83.4%	76.9%	89.2%

Аймгийн төсвийн зарлага 14.6 тэрбум буюу 83.4 хувь, сумын төсвийн зарлага 8.9 тэрбум буюу 76.9 хувь, тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагуудын зарлага 22.2 тэрбум төгрөгийн буюу 89.2 хувийн гүйцэтгэлтэй байна.

2019 онд орон нутгийн төсвийн зардал 60.1 тэрбум төгрөгт хүрч, төлөвлөгөө 7.0 хувиар хэмнэгдэх төлөвтэй байна.

Хүснэгт №4 Төсвийн зардлын гүйцэтгэл 2013-2019\* он /сая.төг/

Зардлын зүйл	I.Нийт зардал	II.Урсгал зардал	Бараа үйлчилгээний зардал	Татаас ба урсгал шилжүүлэг	III.Хөрөнгийн зардал	
2013 он	<b>44,275.4</b>	40,980.1	35,846.5	5,133.6	3,295.3	
2014 он	<b>48,508.9</b>	42,579.3	36,359.8	6,219.5	5,929.6	
2015 он	<b>50,902.6</b>	38,898.3	33,019.5	5,878.8	12,004.3	
2016 он	<b>50,276.0</b>	41,099.5	34,720.0	6,379.5	9,176.5	
2017 он	<b>53,946.5</b>	48,716.8	39,801.5	8,915.3	5,229.7	
2018 он	<b>57,149.6</b>	50,834.7	44,008.9	6,825.8	6,314.9	
2019 он	Төлөвлөгөө	<b>64,837.4</b>	54,779.8	50,065.6	4,714.2	10,057.6
	ХБГүйцэтгэл	<b>60,162.7</b>	52,560.9	47,875.8	4,685.1	7,601.8
	Хувь	<b>92.8%</b>	<b>95.9%</b>	<b>95.6%</b>	<b>99.4%</b>	<b>75.6%</b>

Төсвийн зардлын бүтцийг авч үзвэл урсгал зардалд 87.3 %-ийг зарцуулсан ба үүнээс бараа үйлчилгээний бусад зардалд 79.6%, татаас ба урсгал шилжүүлэгт 7.8%, хөрөнгийн зардалд 12.6 %-ийг тус тус зарцуулахаар хүлээгдэж буй гүйцэтгэлээр тооцоологдож байна. Төсвийн жил дуусч байгаатай холбоотой төсвийн зарлагын хүлээгдэж буй гүйцэтгэл, үүссэн өр төлбөрийг барагдуулахаар төсөвт зохицуулалт хийх, төсвийн хуваарьт өөрчлөлт оруулж тулгамдсан асуудлыг шийдвэрлэхээр төлөвлөж байна.

Аймгийн 2019 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан улсын төсвийн болон орон нутгийн хөрөнгөөр хэрэгжих 91 төсөл арга хэмжээг цахим тендер шалгаруулалт зохион байгуулах журмын дагуу Засгийн газрын худалдан ажиллагааны [www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn) сайтад байршуулан зарласан. Худалдан авах ажиллагааны цахим системийг ашигласнаар тендерийн баримт бичиг, техник эдийн засгийн үндэслэлийг

байршуулан сонирхсон иргэн, хуулийн этгээд бүр харах боломжийг бүрдүүлж тендерт оролцогчдыг мэдээллээр бүрэн хангаж, өрсөлдөх тэгш боломжийг бүрдэж байна.

Аймгийн төсвөөс санхүүжүүлэхээр баталсан хөрөнгө оруулалтын санхүүжилтийн гүйцэтгэлийг харуулбал:

Хүснэгт №5 Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт /сая.төгрөг/

2019.11.22-ны байдлаар

Үзүүлэлт	Нийт батлагдсан	Нийт санхүүжсэн	Гүйцэтгэлийн хувь	Үлдэгдэл санхүүжилт
Орон нутгийн хөрөнгө оруулалт	1,402.40	1,173.40	83.7	229.00
Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалт	1842	1504.3	81.7	337.70
Орон нутгийн авто замын сангийн хөрөнгө оруулалт	342	172.8	50.5	169.20
Байгаль хамгаалах сангийн хөрөнгө оруулалт	5,406.70	3,590.80	66.4	1,815.90
<b>ДҮН</b>	<b>8,993.10</b>	<b>6,441.30</b>	<b>71.6</b>	<b>2,551.80</b>

Аймгийн төсвийн хөрөнгөөр санхүүжүүлэхээр 9.0 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт баталж, 6.4 тэрбум төгрөгийн санхүүжилтийг олгож гүйцэтгэл 71.6 хувьтай байна.

Хөрөнгө оруулалтын санхүүжилтийн гүйцэтгэлийг эх үүсвэр, хөтөлбөр төсөл арга хэмжээ бүрээр толилуулж байна.

2019 оны орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 28 төсөл арга хэмжээнд хэрэгжүүлэхээр 1402.4 сая төгрөг баталсан бөгөөд хүлээгдэж буй гүйцэтгэлээр 1362.4 сая төгрөгийн санхүүжилтийг олгож, санхүүжилтийн хувь 83.7%, тайлант оны хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээ бүрэн хэрэгжихээр байна.

Хүснэгт №6 Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын гүйцэтгэл /мян.төг/

2019.11.22-ны байдлаар

Д/д	Тухайн жилд худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний нэр төрөл, тоо хэмжээ, хүчин чадал	2019 онд батлагдсан	Гүйцэтгэл	Хувь
1	Дашинчилэн сумын Засаг даргын тамгын газрын суудлын автомашиныг шинэчлэх	50,000.0	50,000.0	100%
2	Бүрэгхангай сумын Засаг даргын тамгын газрын суудлын автомашиныг шинэчлэх	50,000.0	50,000.0	100%
3	Орхон сумын Засаг даргын тамгын газрын суудлын автомашиныг шинэчлэх	50,000.0	50,000.0	100%
4	Хангал сумын Засаг даргын тамгын газрын суудлын автомашиныг шинэчлэх	50,000.0	50,000.0	100%
5	Цэцэрлэгийн өргөтгөлийн барилга барих, 75 хүүхэд /Сэлэнгэ сум/	303,500.0	273,146.4	90%
6	Эрүүл мэндийн төвийн барилгын засвар /Могод сум/	250,000.0	242,975.3	97%
7	Сургуулийн барилгын засвар /Баяннуур сум/	150,000.0	143,372.1	96%
8	Баян-Агт сумын Засаг даргын тамгын газрын компьютер, техник хэрэгслийг шинэчлэх	10,000.0	10,000.0	100%
9	Баяннуур сумын Засаг даргын тамгын газар, Соёлын төвийн компьютер, техник хэрэгслийг шинэчлэх	9,830.0	9,830.0	100%
10	Бугат сумын Засаг даргын тамгын газрын компьютер, техник хэрэгслийг шинэчлэх	10,000.0	10,000.0	100%



11	Булган сумын Засаг даргын тамгын газрын компьютер, техник хэрэгслийг шинэчлэх	9,935.5	9,935.5	100%
12	Бүрэгхангай сумын Засаг даргын тамгын газрын компьютер, техник хэрэгслийг шинэчлэх	10,000.0	10,000.0	100%
13	Гурванбулаг сумын Засаг даргын тамгын газрын компьютер, техник хэрэгслийг шинэчлэх	10,000.0	10,000.0	100%
14	Дашинчилэн сумын Засаг даргын тамгын газрын компьютер, техник хэрэгслийг шинэчлэх	10,000.0	10,000.0	100%
15	Могод сумын Засаг даргын тамгын газар, Соёлын төвийн компьютер, техник хэрэгслийг шинэчлэх	10,000.0	10,000.0	100%
16	Орхон сумын Засаг даргын тамгын газрын компьютер, техник хэрэгслийг шинэчлэх	10,000.0	10,000.0	100%
17	Рашаант сумын Засаг даргын тамгын газрын компьютер, техник хэрэгслийг шинэчлэх	10,000.0	10,000.0	100%
18	Сайхан сумын Засаг даргын тамгын газар, Соёлын төвийн компьютер, техник хэрэгслийг шинэчлэх	10,000.0	10,000.0	100%
19	Сэлэнгэ сумын Засаг даргын тамгын газрын компьютер, техник хэрэгслийг шинэчлэх	10,000.0	10,000.0	100%
20	Тэшиг сумын Засаг даргын тамгын газрын компьютер, техник хэрэгслийг шинэчлэх	9,979.8	9,979.8	100%
21	Хангал сумын Засаг даргын тамгын газрын компьютер, техник хэрэгслийг шинэчлэх	9,999.0	9,999.0	100%
22	Хишиг-Өндөр сумын Засаг даргын тамгын газрын компьютер, техник хэрэгслийг шинэчлэх	10,000.0	10,000.0	100%
23	Хутаг-Өндөр сумын Засаг даргын тамгын газрын компьютер, техник хэрэгслийг шинэчлэх	10,000.0	10,000.0	100%
24	Хялганат тосгоны Захирагчийн ажлын албаны компьютер, техник хэрэгслийг шинэчлэх	10,000.0	10,000.0	100%
25	Сумдын Эрүүл мэндийн төвд шаардлагатай тоног төхөөрөмж /14 сум/	134,134.0	134,134.0	100%
26	Дулааны станцын цахилгаан хангамжийг аваарын нөөц эх үүсвэртэй болгох	170,000.0	-	0%
27	Бугат сумын Иргэний танхимын засвар, тохижилтын ажил	10,000.0	10,000.0	100%
28	Нэгдсэн эмнэлгийн моорогийн засварын ажил	15,067.0	-	0%
	<b>Нийт дүн</b>	<b>1,402,445.3</b>	<b>1,173,372.1</b>	<b>83.7%</b>

Орон нутгийн авто замын сангийн хөрөнгөөр хэрэгжих төсөл арга хэмжээний санхүүжилтийн гүйцэтгэл 50.5 % байна. Хүлээгдэж буй гүйцэтгэлээр дөрвөн төсөл арга хэмжээнд 292.0 сая төгрөгийн санхүүжилт олгохоор тооцоологдож байна.

Хүснэгт №7 Авто замын сангийн хөрөнгө оруулалтын гүйцэтгэл /мян.төг/  
2019.11.22-ны байдлаар

Д/д	Тухайн жилд худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний нэр төрөл, тоо хэмжээ, хүчин чадал	2019 онд батлагдсан	Гүйцэтгэл	Хувь
-----	---	---------------------	-----------	------

1	Орон нутгийн чанартай авто замын засвар, арчлалт	175,000.0	125,013.0	71.4%
2	Байгалийн гамшгийн үеийн авто зам, замын байгууламжийн засвар	50,000.0	-	0.0%
3	Булган сумын авто замын засвар, арчлалт	42,000.0	42,000.0	100.0%
4	Зам, тээврийн хяналтын төвийн зардал	15,000.0	5,830.3	38.9%
5	Шинээр хийлгэх зураг төсвийн зардал	60,000.0	-	0.0%
<b>Нийт дүн</b>		<b>342,000.0</b>	<b>172,843.3</b>	<b>50.5%</b>

Аймгийн Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжих төсөл арга хэмжээний санхүүжилтийн гүйцэтгэл 82.0% байна. Хүлээгдэж буй гүйцэтгэлээр 13 төсөл арга хэмжээнд 1789.1 сая төгрөгийн санхүүжилтийг олгохоор тооцоолж байна.

Хүснэгт №8 Аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн гүйцэтгэл /мян.төг/

2019.11.22-ны байдлаар

Д/д	Тухайн жилд худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний нэр төрөл, тоо хэмжээ, хүчин чадал	2019 онд батлагдсан	Гүйцэтгэл	Хувь
1	Техник технологи, инноваци нутагшуулах, үйлдвэрлэлийн бүсийн үйл ажиллагааны техник эдийн засгийн үндэслэл боловсруулах	49,000.0	-	0%
2	Аймгийн Аудитын газрын актын дагуу 2018 онд хэрэгжүүлсэн арга хэмжээний дутуу санхүүжилт	66,804.2	66,804.1	100%
3	Эмнэлгийн шинэ, хуучин барилгыг холбох /Хишиг-Өндөр сум/	30,000.0	-	0%
4	Сургуулийн спорт заалны барилга шинээр барих /Орхон сум/	250,000.0	228,430.5	91%
5	Аймгийн өвс тэжээлийн нөөц бүрдүүлэх	50,000.0	32,697.5	65%
6	Эрүүл мэндийн төвд лабораторийн тоног төхөөрөмж /Гурванбулаг сум/	18,481.5	18,481.5	100%
7	Эрүүл мэндийн төвийн барилгын их засвар /Баян-Агт сум/	241,500.0	218,066.9	90%
8	Эрүүл мэндийн төвийн барилгын их засвар /Хялганат тосгон/	209,575.8	209,450.1	100%
9	Булган аймгийн Нэгдсэн эмнэлгийн 50 ортой төрөх эмнэлгийн барилгын дээврийн засвар	91,312.5	91,303.6	100%
10	Соёлын төвийн засвар /Хангал сум/	245,699.6	123,071.2	50%
11	Цэцэрлэгийн барилгын өргөтгөл 120 хүүхэд /Тэшиг сум/	350,000.0	329,040.8	94%
12	Булган сумын төвийн хяналтын камерын засвар	10,000.0	-	0%
13	2018 онд хэрэгжсэн барилга байгууламжийн техник эдийн засгийн үндэслэл, зураг төсөв боловсруулах ажлын дутуу санхүүжилт, 2019 онд хэрэгжүүлэх барилга байгууламж техник эдийн засгийн үндэслэл, зураг төсөв боловсруулах ажил	190,140.2	147,468.8	78%
14	Аймгийн баяр наадмыг тэмдэглэх	39,514.6	39,514.6	100%
<b>Нийт дүн</b>		<b>1,842,028.5</b>	<b>1,504,329.6</b>	<b>82%</b>



Аймгийн Байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардлаар 73 төсөл арга хэмжээнд 5406.7 сая төгрөгийн санхүүжилт олгохоос 60 төсөл арга хэмжээнд 3590.9 сая төгрөгийн санхүүжилтийг олгосон байна.

Хүснэгт №9 Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлын гүйцэтгэл /мян.төг/ 2019.11.22-ны байдлаар

Д/д	Тухайн жилд худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний нэр төрөл, тоо хэмжээ, хүчин чадал	2019 онд батлагдсан	Гүйцэтгэл	Санхүүжилтийн хувь
1	Ойжуулалт /300 га, Бугат, Сэлэнгэ, Могод, Хангал/	197,708.0	180,956.0	92%
2	Зоон давааны орчинд хамгаалалтын ойн зурвас байгуулах	38,374.0	19,186.9	50%
3	Ойн хортны тэмцлийн ажил хийх /Орхон, Хутаг-Өндөр, Баян-Агт, Хангал, Бүрэгхангай, Сэлэнгэ, Бугат, Тэшиг 23100 га/	294,788.0	294,788.0	100%
4	Ой бүхий сумдад ойн хортны судалгааны ажил /200000 га/	16,955.5	16,955.5	100%
5	Ойн ангид арчилгааны огтлолт хийх зориулалтын моторт хөрөө авах	6,990.0	6,990.0	100%
6	Ойн нөхөрлөлүүдийн ойн санд ой зохион байгуулалт хийлгэх /20 ойн нөхөрлөл/	17,000.0	-	0%
7	Хялганат тосгоны сум дундын Ойн ангийн мод үржүүлгийн газрын өргөтгөл	50,000.0	47,029.5	94%
8	Элсний нүүдлээс хамгаалах /Хутаг-Өндөр, Сэлэнгэ, Орхон сум/	15,000.0	10,000.0	67%
9	Ногоон байгууламжийг нэмэгдүүлэх, арчилгаа хийх /Аймгийн хэмжээнд/	70,000.0	44,969.7	64%
10	Байгаль орчны хяналтын улсын байцаагч, байгаль хамгаалагч, тусгай хамгаалалтын газар нутгийн захиргааны байгаль хамгаалагч нарын зөвлөгөөн зохион байгуулах	15,000.0	8,019.6	53%
11	Тэшиг сумын төвийн цэцэрлэгт хүрээлэнгийн тохижилт, ногоон байгууламж	20,000.0	20,000.0	100%
12	Идэвхтэн байгаль хамгаалагч, морин эргүүл ажиллуулах зардал /Бугат, Хутаг-Өндөр, Сэлэнгэ, Хангал, Тэшиг, Орхон/	12,960.0	2,960.0	23%
13	Булган сумын үерийн далан шинэчлэн засварлах /Булган сум 6-р хэсэг/	31,615.2	-	0%
14	Орхон голын Зүр хүзүүний гарамд барих гатлага онгоцны үлдэгдэл санхүүжилт	25,400.0	23,090.9	91%
15	Рашаант сумын цэвэрлэх байгууламж	100,000.0	92,140.0	92%
16	Хануй голын Ангархайн замын засвар, шинэчлэлт /Баян-Агт сум/	467,000.0	352,771.0	76%
17	Сайхан сумын инженерийн шугам сүлжээ	300,000.0	294,811.0	98%
18	Булган сумын Эрдмийн өргөө цогцолбор сургуулийн ариун цэврийн байгууламжийн засвар	57,000.0	57,000.0	100%
19	Цэцэрлэгүүдийн ариун цэврийн байгууламж барих /Дашинчилэн, Гурванбулаг, Хишиг-Өндөр сум, Булган	282,202.3	158,619.6	56%

	сумын 3-р цэцэрлэг/			
20	Эргийн бэхэлгээний ажлын зураг төсөл боловсруулах /Сэлэнгэ сум, Хутаг-Өндөр сум Хонгор баг/	90,069.0	75,598.5	84%
21	Усны тоо бүртгэлийн ажлыг зохион байгуулах	6,050.0	5,560.0	92%
22	Булаг шандын эх болон хүн амын усан хангамжийн худагт эрүүл ахуйн бүсийн хамгаалалтын хашаа барих ажлын жишиг зураг, төсөл боловсруулах	600.0	586.5	98%
23	Усан хамгамж, ариутгах татуурга, төвлөрсөн шугам, сүлжээний ажлын зураг, төсөл боловсруулах /Дашинчилэн сум/	42,000.0	42,000.0	100%
24	Булаг шандны эхийг хашиж хамгаалах /10 булаг/	37,650.0	37,650.0	100%
25	Хүн амын усан хангамжийн худагт эрүүл ахуйн шаардлага хангасан ус нөөцлөх сав суурилуулах /Сэлэнгэ, Баяннуур, Орхон, Дашинчилэн, Бүрэгхангай сум/	16,500.0	16,500.0	100%
26	Хүн ам болон бэлчээрийн усан хангамжийг сайжруулах зориулалтаар шинээр инженерийн хийцтэй худаг гаргах /12 ш/	187,147.2	151,684.1	81%
27	Ундны ус ариутгах хлоржуулалтын тоног төхөөрөмж /Булган сум/	59,000.0	59,000.0	100%
28	Хутаг-Өндөр суманд үерийн далан барих	638,900.0	68,026.0	11%
29	Рашаант суманд үерийн далан барих	140,000.0	87,795.4	63%
30	Сав газруудын талуудын оролцооны зөвлөлийн хурал, зөвлөгөөн	15,000.0	11,186.0	75%
31	Ногоон хөгжлийн бодлогын дэд хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх арга хэмжээ	150,000.0	99,923.4	67%
32	Байгаль орчны багц хуулийн хэрэгжилтийн хяналт шалгалт	38,000.0	25,750.5	68%
33	Сав газруудын хамгаалалтын бүс тогтоох	50,000.0	-	0%
34	Могод сумын төвд халаалтын зуухнаас Эрүүл мэндийн төв хүртэлх цэвэр усны шугам сүлжээний ажил	30,000.0	-	0%
35	Дашинчилэн сумын төвийн ундны усан хангамжийг шинэчлэх	20,000.0	-	0%
36	Булган сумын өрхийн эрүүл мэндийн төвийн халаалтын тогоог шинэчлэх	10,000.0	10,000.0	100%
37	Халдварт сүрьеэгийн барилгын бохирын шугамыг шинэчлэх	8,500.0	-	0%
38	Шинээр төлөвлөгдсөн 320 айлын орон сууцны хорооллын инженерийн шугам сүлжээний зураг төсөл	22,431.5	22,431.5	100%
39	Сайхан, Могод суманд хөв цөөрөм байгуулах ажлын үлдэгдэл санхүүжилт	28,273.8	-	0%

40	Булган сумын 1 дүгээр багийн гэр хорооллын айл өрхөд хог төрөлжүүлэн хийх хогийн сав нийлүүлэх /138 ш/	66,911.6	65,820.0	98%
41	Булган сумын 2 дугаар багийн гэр хорооллын айл өрхөд хог төрөлжүүлэн хийх хогийн сав нийлүүлэх /136 ш/	65,772.6	64,603.1	98%
42	Булган сумын 3 дугаар багийн гэр хорооллын айл өрхөд хог төрөлжүүлэн хийх хогийн сав нийлүүлэх /139 ш/	68,749.2	67,507.8	98%
43	Булган сумын 4 дүгээр багийн гэр хорооллын айл өрхөд хог төрөлжүүлэн хийх хогийн сав нийлүүлэх /146 ш/	71,102.0	69,680.0	98%
44	Булган сумын 6 дугаар багийн гэр хорооллын айл өрхөд хог төрөлжүүлэн хийх хогийн сав нийлүүлэх /144 ш/	70,937.2	69,683.6	98%
45	Булган сумын нийтийн эзэмшлийн талбайд хог төрөлжүүлэн хийх хогийн сав байршуулах /130 ш/	62,822.5	61,614.4	98%
46	Сумдын нийтийн эзэмшлийн талбайд хогийн сав байршуулах	84,123.2	84,123.2	100%
47	“Цэвэр орчин” аяныг 16 сум, 1 тосгонд зохион байгуулах	17,000.0	4,305.1	25%
48	Бүх төрлийн зургийг хэвлэх плоттер хэвлэгч худалдан авах /Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар/	17,200.0	17,200.0	100%
49	Багийн хилийн заагийг баталгаажуулах /16 сум/	13,206.6	8,405.3	64%
50	Доройтсон бэлчээрийг зайнаас тандан судлах, нөхөн сэргээх, туршилт судалгааны төв барих /Гурванбулаг сум/	300,000.0	259,005.6	86%
51	Булган аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө хийлгэх	300,000.0	-	0%
52	Газрын хэвлий, хөрсөнд учруулсан хохирлыг мэргэжлийн байгууллагаар тогтоолгох зардал	19,200.0	19,200.0	100%
53	Хог хаягдлын цэгийг дарж булах, өөр газар шилжүүлэх /Хутаг-Өндөр сумын Хантай баг/	10,000.0	10,000.0	100%
54	Хог хаягдлын цэгийг дарж булах, өөр газар шилжүүлэх /Хутаг-Өндөр сумын Хонгор баг/	10,000.0	10,000.0	100%
55	Хог хаягдлын цэгийг дарж булах, өөр газар шилжүүлэх /Хангал сумын Хялганат тосгон	20,000.0	20,000.0	100%
56	Хог хаягдлын цэгийг дарж булах, өөр газар шилжүүлэх /Рашаант сум/	20,000.0	20,000.0	100%
57	Нутаг дэвсгэрийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөө боловсруулах /Бугат, Орхон, Тэшиг, Хишиг-Өндөр, Хутаг-Өндөр, Хангал, Дашинчилэн сум/	293,500.0	234,800.0	80%
58	Байгаль орчны тэмдэглэлт өдрүүдээр иргэдэд зориулсан сургалт сурталчилгаа, эко уралдаан зохион	10,000.0	7,269.8	73%

	байгуулах /5 удаа/			
59	Булган сумын агаарын бохирдлын явуул судалгааны агаараас дээж авагч төхөөрөмж худалдан авах	9,000.0	9,000.0	100%
60	Хөрсний шинжилгээний боловсруулалтад хэрэглэгдэх төхөөрөмж худалдан авах	1,000.0	1,000.0	100%
61	Цаг агаарт зориудаар нөлөөлөх ажилд дэмжлэг үзүүлэх /Тусгай зориулалттай автомашин, багаж техник хэрэгсэл/	40,000.0	40,000.0	100%
62	Байгаль орчин аялал жуулчлалын газарт албан хэрэгцээний автомашин	35,000.0	35,000.0	100%
63	Байгаль хамгаалагчдын иж бүрэн ажлын хувцас /30 ширхэг/	28,950.0	28,950.0	100%
64	Байгаль орчин, аялал жуулчлалын газарт шилэн кабель татах	10,000.0	-	0%
65	Булган сумын хог хаягдлыг ангилан ялгах цехэд худаг гаргах	9,000.0	-	0%
66	Аялал жуулчлалын танилцуулга бэлтгэх	9,000.0	-	0%
67	Хог тээврийн автомашин /Булган, Рашаант /	86,028.5	-	0%
68	Баян-Агт сумын хогийн цэгийг хашаажуулах	9,376.6	-	0%
69	Орхон сумын хогийн цэгийн даланг засварлах	8,000.0	8,000.0	100%
70	Тусгай хамгаалалттай газар нутагт биотехникийн арга хэмжээ авах /Зэд-Хантай-Бүтээлийн нурууны дархан цаазат газар, Хөгнө-Тарны тусгай хамгаалалттай газар/	6,000.0	6,000.0	100%
71	Ховор ургамал болох "Заан хүж"-ийг хамгаалах /Баян-Агт сум/	3,000.0	3,000.0	100%
72	Аймгийн хэмжээнд ерөнхий агнуур зохион байгуулалт хийлгэх	19,713.4	19,713.4	100%
73	Үйл ажиллагааны зардал	4,000.0	2,990.4	75%
	<b>Нийт дүн</b>	<b>5,406,707.8</b>	<b>3,590,851.0</b>	<b>66.4</b>

#### 4.2 Аймгийн 2020 оны төсвийн урсгал зардлын тойм

Аймгийн 2020 оны төсвийн төслийг Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлд заасан төсвийн зарчим, хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хууль эрх зүйн орчин, заавар журмын хүрээнд статистик тоо мэдээ, үнэ ханш зэрэг өөрчлөлтүүд, урсгал төсвийн зарлагын шинэчлэлийг тусган тооцоолж боловсрууллаа.

Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх, төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлэн, төсвийн зарлагын шинэчлэлийг хэрэгжүүлж, төсвийн үр ашгийг нэмэгдүүлэх бодлогын хүрээнд орон нутгийн төсвийн байгууллагуудын хэвийн үйл ажиллагааг хангахад зарим зардал хүрэлцэхгүй байгааг харгалзан төсвийн урсгал зарлагатай холбоотой дараах арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн. Үүнд:

- 2020 онд төрийн албан хаагчдын үндсэн цалинг 8 хувиар нэмэгдүүлэхээр тооцоолж, орон нутгийн төсвийн байгууллагын үндсэн цалин, нэмэгдэл хөлс, нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг өмнөх оноос 1126.9 сая төгрөгөөр нэмэгдүүлэн тооцлоо.
- Төрийн албаны тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.2.4 заалт, төрийн албаны мэргэшсэн, тогтвортой байх зарчмыг хангах зорилгоор 2020.01.01-нээс төрийн үйлчилгээний албан хаагчид төрийн алба хаасан хугацааны нэмэгдлийг олгохоор шийдвэрлэсэн. Орон нутгийн төсвийн байгууллага, нийтийн биеийн тамир, соёлын байгууллагад ажиллаж буй төрийн үйлчилгээний албан хаагчдын төрийн албан хаасан хугацааг харгалзан үндсэн цалингаас нэмэгдлийг бодож тооцооллоо.
- Монгол улсын засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн орон нутгийн өөрөө удирдах болон засаг захиргааны байгууллагын хэрэгжүүлэх чиг үүргийг харгалзан аймгийн ИТХ-ын төсвийг 473.9 сая, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зохицуулах зөвлөлийн зардлыг Шүүхийн шийдвэр биелүүлэх, замын хөдөлгөөний болон хэв журмын зөрчлийг арилгах, торгох ял ногдуулж төсөвт тушаасан орлогын гүйцэтгэлд үндэслэн 90,0 сая төгрөгөөр тооцлоо.
- Аймгийн Засаг дарга, түүний Тамгын газрын үйл ажиллагааны төсвийг 1743.1 сая, сумдын ИТХ, ЗДТГ, Ойн ангийн үйл ажиллагааг хэвийн, тасралтгүй явуулахад шаардагдах тээвэр шатахуун, бичиг хэрэг, урсгал засвар, дотоод албан томилолтын зардлыг шинэчлэгдсэн тариф зэргийг харгалзан ИТХ, ЗДТГ, Ойн ангийн төсвийн суурь зардлыг нийт 7711.6 сая төгрөгөөр тооцов.
- Төрийн үйлчилгээний албан хаагч нь төрийн захиргааны албан хаагчийн адил төрд ажилласан хугацаагаараа тооцуулж тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн тэтгэмж авах боломжтой болсон. 2020 онд орон нутгийн төсвийн байгууллага, соёлын байгууллагаас өндөр насны тэтгэвэрт гарах 28 төрийн албан хаагчид 455.1 сая төгрөгийг нэг удаагийн буцалтгүй тусламж олгохоор тооцооллоо.
- Аймгийн Ахмадын холбооны сумын ахмадын хорооны үйл ажиллагааг дэмжих зорилгоор сум бүрт 0.5 сая төгрөг нийт 8.5 сая төгрөгийг сумдын Засаг даргын тамгын газрын суурь зардалд тусгасан.
- Байгаль орчин аялал жуулчлалын газар, Санхүүгийн хяналт аудитын алба, Орон нутгийн Өмчийн газар, Хүүхдийн сувиллын ясли зэрэг байгууллагуудын зардлыг Сангийн яамнаас хянаж баталсан 2019 оны суурь зардлын түвшинд төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг бууруулахгүй байх хэмжээнд тооцож төлөвлөсөн.
- “Авто тээврийн тухай”, “Ахмадын тухай”, “Хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгмийн хамгааллын тухай” зэрэг хуулийн дагуу Булган хот доторхи зорчигч тээврийн нөхөн олговрыг тооцож 12,0 сая төгрөг тусгалаа.
- Аймаг, сумын Засаг даргын нөөц хөрөнгөөс шагнал, урамшуулал, буцалтгүй тусламж, уналга, цугларалт, бэлтгэл сургуулилт, мал тооллогын зардал, байгалийн гамшиг, ослын үр дагаврыг арилгах, гоц халдварт өвчний голомтыг арилгах, тархалтыг хязгаарлах болон Засаг даргын хуулиар олгогдсон бүрэн эрхээ хэрэгжүүлэхтэй холбоотой цаг үеийн шинжтэй зарим арга хэмжээг санхүүжүүлдэг. Аймгийн Засаг даргын нөөц хөрөнгийг 350.0 сая, сумын Засаг даргын нөөц хөрөнгийг тус бүр 10.0 сая төгрөг, нийт 520.0 сая төгрөг тусгаж, Сангийн яамнаас өгсөн суурь зардлыг 272.2 сая төгрөгөөр нэмэгдүүлсэн байна.
- Нийгмийн халамжийн сангийн орон нутгийн төсвөөс санхүүжих олон нийтийн оролцоо түшиглэсэн халамжийн үйлчилгээний зардалд 24,0 сая, амьжиргааг дэмжих нөхцөлт мөнгөн тусламжид 55,2 сая төгрөг нийт 79.2 сая төгрөгийг зориулалтын дагуу санхүүжүүлнэ.

- 2019 оны есдүгээр сараас төвлөрсөн халаалтад холбогдсон Баян-Агт сумын төрийн байгууллагуудын түлш халаалтын зардлыг тооцоолж нийт 466.1 сая төгрөгийг тусгалаа. Өмнө оны суурь түвшингээс 379.1 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.
- Орон нутгийн сургууль, цэцэрлэг, сумын эрүүл мэндийн төв, тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагын байр ашиглалтын зардал /гэрэл цахилгаан, түлш халаалт, цэвэр бохир ус, байрны түрээс, урсгал засвар/-ыг 2019 оны хүлээгдэж буй гүйцэтгэл, улс болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр 2020 онд шинээр ашиглалтад орох барилга, байгууламжийн ашиглалтын зардал зэргийг тооцоолж 5.0 тэрбум төгрөг тусгалаа.
- Мал, амьтны эрүүл мэндийн тухай хууль батлагдсантай холбоотой мал, амьтны өвчнөөс урьдчилан сэргийлэх эм, тарилга, вакцины төлбөрт 167.3 сая, орон нутгийн төсвөөс мал эмнэлгийн үйлчилгээний зардалд 439.9 сая төгрөгийг олгохоор төсөвт тусгалаа.
- Аймгийн Гамшгаас хамгаалах санд аймгийн төсвөөс 100.0 сая, аймгийн Цэргийн дүйцүүлэх албаны зардлыг 85.0 сая төгрөгөөр тооцооллыг хийсэн.

#### 4.3 Орон нутгийн 2020 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөө

Хүснэгт №10 Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт

№	Төсөл арга хэмжээний нэр	Хэрэгжих он	Төсөвт өртөг /мян.төг/	Тайлбар
1	Цэцэрлэгийн өргөтгөлийн барилгын дуусгал /Сэлэнгэ сум/	2019-2020	489,122.6	Он дамнаж хийгдэж буй ажил
2	Цэнгэлдэх хүрээлэнгийн засвар, шинэчлэлтийн ажлын нэмэлт санхүүжилт	2019-2020	54,291.7	Шүүхийн шийдвэрээр олгох
<b>ДҮН</b>			<b>543,414.3</b>	

##### 4.3.2 Орон нутгийн хөгжлийн сан

Орон нутгийн хөгжлийн санд хуваарилагдан ирсэн 3.8 тэрбум төгрөгийг Засгийн 2018 оны 228 дугаар тогтоолоор шинэчлэн батлагдсан “Орон нутгийн нэгдсэн сан болон орон нутгийн хөгжлийн сангаас олгох орлогын шилжүүлгийг тооцох аргачлал”-ыг үндэслэн 1.3 тэрбум төгрөгийг сумын орон нутгийн хөгжлийн санд, 1.9 тэрбум төгрөгийг аймгийн орон нутгийн хөгжлийн санд, суурь зарлагын санхүүжүүлэхээр 0.5 тэрбум төгрөгийг хуваариллаа.

Дээрх аргачлын дагуу сумдын орон нутгийн хөгжлийн санд итгэлцүүрт үндэслэн 711.1 сая, ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий 11 суманд 335.8 сая төгрөг, Тогтвортой амьжиргаа-3 төслийн дэмжлэг 116.6 сая, төслийн урамшуулал авах нөхцөл хангасан нэр бүхий 8 суманд 117.4 сая төгрөг хуваарилснаар нэг суманд дунджаар 44.8-135.2 сая төгрөг ногдож байна.

Хүснэгт №11 Сумдын орон нутгийн хөгжлийн санд олгох орлогын шилжүүлгийн тооцоолол

